



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/174

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох, хугацаа
сунгах, нэмэлт оруулах тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 15 дугаар зүйлийн 15.8.2, 15.8.5, Тусгай зөвшөөрөл олгоход урьдчилсан дүгнэлт гаргах комиссын 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 07/22 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ, зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр хавсралт ёсоор, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах хуулийн этгээдийн жагсаалтыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ, зуух, даралтат сав, шугам хоолойн техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөл боловсруулах ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах хуулийн этгээдийн жагсаалтыг гуравдугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд нэмэлт ажлын төрөл олгох хуулийн этгээдийн жагсаалтыг дөрөвдүгээр хавсралт ёсоор баталсугай.

4. Тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулан, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт үүрэг болгосугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

170600416

Эрчим хүчний сайдын 2022 оны 09 дүгээр
сарын 05-ны өдрийн А/174 дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт



Эрчим хүчний эх үүсвэр, шугам, сүлжээ, зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт,
засвар, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг
шинээр олгох хуулийн этгээдийн жагсаалт

Д/д	Компанийн нэр, регистрийн дугаар	Гэрчилгээний дугаар, хугацаа	Код	Үйл ажиллагааны төрөл
1. Цахилгааны чиглэлээр				
1	“Юнайтед коммуникэйшн оф монголиа” ХХК, 6607926, Баянзүрх дүүрэг	2184/22 2022-09-05-ны өдрөөс 3 жил	T3-2.1	0.4-15 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт, тохируулгын ажил үйлчилгээ
2	“Ашид бүтэмж” ХХК (ГХО), 5048362, Баянзүрх дүүрэг	2185/22 2022-09-05-ны өдрөөс 3 жил	T3-2.1	0.4-15 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт, тохируулгын ажил үйлчилгээ (“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-н газрын тосны хайгуул, ашиглалтын 19, 21-р талбайн цахилгаан дамжуулах шугам, дэд станцын хүрээнд)
3	“Эн Эй Пи Оү Жи Эс” ХХК, 6824617, Сүхбаатар дүүрэг	2186/22 2022-09-05-ны өдрөөс 3 жил	T3-2.1	0.4-15 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт, тохируулгын ажил үйлчилгээ
4	“Эн И Ти Эл” ХХК, 4489985, Налайх дүүрэг	2187/22 2022-09-05-ны өдрөөс 3 жил	T3-2.2	0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт, тохируулгын ажил үйлчилгээ
5	“Нар энерги селикон метал” ХХК, 5502845, Баянзүрх дүүрэг	2188/22 2022-09-05-ны өдрөөс 3 жил	T3-1.1 T3-2.2	0.01 - 5 МВт-ын хүчин чадалтай цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн угсралт, засварын ажил, түүний туршилт, тохируулгын ажил үйлчилгээ 0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт, тохируулгын ажил үйлчилгээ

Эрчим хүчний сайдын 2022 оны 09 дүгээр
сарын 05-ны өдрийн А/174 дүгээр тушаалын
хоёрдугаар хавсралт



Эрчим хүчний эх үүсвэр, шугам, сүлжээ, зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах хуулийн этгээдийн жагсаалт

Д/д	Компанийн нэр, Регистрийн дугаар	Гэрчилгээний дугаар, хугацаа	Код	Үйл ажиллагааны төрөл
1. Цахилгааны чиглэлээр				
1	“Автомастер төв” ХХК, 2690586, Орхон аймаг, Баян-Өндөр сум	1500/22 2022-09-05-ны өдрөөс 5 жил	T3-2.1	0.4-15 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт, тохируулгын ажил үйлчилгээ
2	“Чандманьхонгор групп” ХХК, 5478022, Өмнөговь аймаг, Даланзадгад сум	1184/22 2022-09-05-ны өдрөөс 5 жил	T3-2.1	0.4-15 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт, тохируулгын ажил үйлчилгээ
3	“Бриджконстракшн” ХХК, 2593009, Баянзүрх дүүрэг	1845/22 2022-09-05-ны өдрөөс 5 жил	T3-1.4 T3-2.3	0.01 - 100 МВт-ын хүчин чадалтай цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн угсралт, засварын ажил, түүний туршилт, тохируулгын ажил үйлчилгээ 0.4-110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт, тохируулгын ажил үйлчилгээ
2. Дулааны чиглэлээр				
4	“Ихбага хонгор” ХХК, 2702355, Баянгол дүүрэг	021/22 2022-09-05-ны өдрөөс 5 жил	T3-4.2 T3-7.2	0.07-4.0 МПа /0.7-40 кгх/см ² / даралттай даралтат савны угсралт, засварын ажил, түүний туршилт, тохируулгын ажил үйлчилгээ 4.0 МПа /40 кгх/см ² /-аас дээш даралтанд ажилладаг тоноглолын угсралт, засварын ажил, түүний туршилт, тохируулгын ажил үйлчилгээ

Эрчим хүчний сайдын 2022 оны 09 дүгээр
сарын 05-ны өдрийн А/174 дүгээр тушаалын
гуравдугаар хавсралт



Эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ, зуух, даралтат сав, шугам хоолойн техник,
эдийн засгийн үндэслэл, зураг, төсөл боловсруулах ажил, үйлчилгээ эрхлэх тусгай
зөвшөөрлийн хугацааг сунгах аж ахуйн нэгж, байгууллагууд

Д/д	Компанийн нэр, Регистрийн дугаар	Гэрчилгээний дугаар, хугацаа	Код	Үйл ажиллагааны төрөл
1	"Монцахэр" ХХК, 2857839, Сүхбаатар дүүрэг	ЗТ-70/22 2022-09-05-ны өдрөөс 5 жил	ТЗ-8.4	0.4-110 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын барилга байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах

Эрчим хүчний сайдын 2022 оны 09 дүгээр
сарын 05-ны өдрийн А/174 дүгээр тушаалын
дөрөвдүгээр хавсралт



**Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд нэмэлт ажлын төрөл олгох
аж ахуйн нэгж, байгууллагууд**

Д/д	Компанийн нэр, Регистрийн дугаар	Гэрчилгээний дугаар, хугацаа	Код	Үйл ажиллагааны төрөл
1	“Альянстех” ХХК, 2664453, Баянгол дүүрэг	304/21 2026-09-09-ний өдөр хүртэл	ТЗ-1.5 ТЗ-2.2	0.01-100 МВт-ын хүчин чадалтай дулааны эрчим хүчний эх үүсвэрийн угсралт, засварын ажил, түүний туршилт, тохируулгын ажил үйлчилгээ 0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт, тохируулгын ажил үйлчилгээ